

**БНХАУ-ЫН ДАРГА СИ ЗИНЬПИНИЙ ОХУ-Д ХИЙСЭН
АЖЛЫН АЙЛЧЛАЛ, ОРОС-ХЯТАДЫН СТРАТЕГИЙН
ТҮНШЛЭЛИЙН ӨРНӨЛТ**

А.Нямдолжин *

Товч утга

БНХАУ-ын дарга Си Зиньпин 2013 оны 3-р сарын 22-24-ний өдрүүдэд ОХУ-д ажлын айлчлал хийсэн нь дэлхийн олон нийтийн анхаарлыг ихэд татлаа. Өмнөд хөршийн төрийн тэргүүн хилийн чанадад хийх анхны айлчлалаа ОХУ-аас эхэлсэн нь Хятадын шинэ удирдагчид дэлхийн улс төр, эдийн засагт эзлэх байр суурь нөлөөгөө бэхжүүлэх үүднээс орос-хятадын стратегийн түншлэлээ улам зузаатган бэхжүүлэх гадаад бодлогын чиг шугамыг хэвээр хэрэгжүүлж байгаагаа нотлон харууллаа. Айлчлалын үеэр хоёр улсын хамтын ажиллагааны бүхий л чиглэлийг хамарсан 35 багц баримт бичигт гарын үсэг зурсан нь үүний илрэл юм.

Түлхүүр үг: эрчим хүч, нефть, байгалийн хий, худалдаа, хамтын ажиллагаа

ОХУ, БНХАУ-ын эдийн засгийн хамтын ажиллагаа 1999 оноос эхлэн тогтвортой өсч байгаа бөгөөд ялангуяа сүүлийн жилүүдэд хоёр талын худалдааны эргэлт огцом нэмэгдэж байна. Сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд ОХУ, БНХАУ-ын төрийн тэргүүнүүдийн удаа дараагийн харилцан айлчлал, засгийн газар хоорондын уулзалтын дүнд хоёр улсын хоорондын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа амжилттай өргөжин тэлж, тасралтгүй эрчимжин хөгжиж байна.

2013 оны 3-р сарын 22-ноос 24-ний өдрүүдэд БНХАУ-ын дарга Си Зиньпин ОХУ-д хийсэн төрийн айлчлалын үеэр хоёр улсын тэргүүн нар худалдаа-эдийн засаг, эрчим хүч, өндөр технологи, байгаль орчин, соёл, аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах болон олон улсын үйл явдлын талаар санал бодлоо солилцож, “Бүх

*А.Нямдолжин-Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

талын, стратегийн түншлэлийн харилцааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх, харилцан ашигтай хамтын ажиллагааны тухай хамтарсан мэдэгдэл”¹-д гарын үсэг зурсан байна.

Шинэ үеийн орос-хятадын харилцааны үндэс суурь нь их гүрнүүдийн нийтлэг ашиг сонирхол, геополитикийн тэнцвэртэй байдлыг хадгалах, дэлхий дахины улс төр ба эдийн засгийн өөрчлөлтүүд дээр суурилан “сайн хөршийн харилцаа, хамтын ажиллагаа”, “харилцан ашигтай хамтын ажиллагаа”, “стратегийн түншлэл”, “бүх талыг хамарсан иж бүрэн түншлэл”-ийн харилцаагаар тодорхойлогдож байна. Айлчлалын үеэр хоёр улсын хамтын ажиллагааны бүхий л чиглэлийг хамарсан 35 багц баримт бичгүүдэд гарын үсэг зурж, худалдаа, эдийн засаг, нефть, эрчим хүч, хөрөнгө оруулалтын салбарт онцгой анхаарал хандуулав. Сүүлийн 20 жилд хоёр орны хоорондын бараа эргэлт 14 дахин нэмэгдсэн бөгөөд бараа эргэлтийн хэмжээ өнгөрсөн онд 88,16 тэрбум ам.долларт хүрсэн ба 2013 онд энэ үзүүлэлт 100 тэрбум, 2020 онд 200 тэрбумд хүрнэ гэж үзэж байна.²

Дэлхийн хамгийн олон хүн амтай, хамгийн их үйлдвэрлэл хөгжсөн Хятад улсын эдийн засаг хурдацтай өсөхийн хэрээр эрчим хүч, нефть, байгалийн хийн хэрэглээ ч эрс нэмэгдэж байгаа нь энэ чиглэлээр хоёр орон харилцан ашигтай хамтран ажиллах таатай нөхцлийг бүрдүүлж байна. ОХУ байгалийн хий болон модны нөөцөөрөө дэлхийд тэргүүлж, нүүрсний орд газрын нөөцөөр хоёрт, алтны орд газраараа гуравт ордог. Нөөцийн ихэнх хэсэг нь Зүүн Сибирь, Алс Дорнодод оршдог нь байршлын хувьд хятадын хэрэглэгчдэд давуу талтай хэмээн хоёр тал үзэж байна. Тэр ч утгаараа айлчлалын хүрээнд талууд эрчим хүчний хамтын ажиллагааны тухай нилээд хэдэн чухал баримт бичгүүдэд гарын үсэг зурлаа. “Роснефть” компани болон Хятадын Үндэсний нефтийн (China National Petroleum Corporation) корпорацийн хооронд урьдчилсан төлбөр хийх нөхцөлтэйгээр түүхий нефть нийлүүлэх үндсэн нөхцлүүдийн тухай хэлэлцээр-3т гарын үсэг зурж, 2011 оноос Хятад улс руу жилд 15 сая тонн нефть нийлүүлж байгаа бөгөөд цаашид 31 сая тонн хүртэл түүхий нефть нийлүүлэлтийн хэмжээг нэмэгдүүлэхээр болжээ. Түүнчлэн “Роснефть” болон Хятадын төрийн банкны хооронд 25 жилийн хугацаатай 2 тэрбум ам.долларын зээлийн гэрээнд гарын үсэг зурлаа.⁴ Мөн “Роснефть” болон Хятадын Үндэсний нефтийн корпорацийн хооронд нүүрс устөрөгч, геологи судлал, хайгуулын салбарт стратегийн түншлэлийн тухай хэлэлцээрт гарын үсэг зуржээ. “Роснефть” компани нь 1993 онд улсын үйлдвэрийн газар

болон байгуулагдсан, долоон том нефть боловсруулах компанийг багтаадаг, жилд 50,9 сая тонн нефть олборлох хүчин чадалтай, шатахуун түгээх станцийн тоогоор Орост хоёрт ордог бөгөөд Оросын 41 бүс нутагт 1800 шатахуун түгээх станцтай компани юм.⁵

Оросын “Газпром” компани болон Хятадын Үндэсний нефтийн корпорацийн хооронд Хятадын зүүн чиглэлээр байгалийн хий нийлүүлэх хоолойн төслөөр хамтын ажиллагааны салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцох санамж бичигт гарын үсэг зурав. Үүний үндсэн дээр “Сибирийн эрч хүч” хэмээх хийн хоолой барьж, 2017 оны сүүлээр ашиглалтанд оруулан 2018 оноос Орос улс Хятад улс руу 30 жилийн хугацаатай жилд 38 тэрбум шоо метр хий нийлүүлж эхлэх бөгөөд цаашид жилд 60 тэрбум хүртэл нэмэгдүүлэх боломжтой юм. Гэрээний үндсэн нөхцлийн эрх үүрэгт энэ оны 7 дугаар сард гарын үсэг зурах ба оны сүүлээр урт хугацааны гэрээнд гарын үсэг зурахаар төлөвлөөд байна.⁶ Оросын “Газпром” компани нь байгалийн хий ба нефтийн хайгуул, олборлолт, тээвэрлэлт, хадгалалт, боловсруулалт хийдэг, дулаан, цахилгаан эрчим хүч нийлүүлдэг, үйлдвэрлэдэг, улсын валютын орлогын 20 хувь, улсын төсвийн 25 хувийг тус тус бүрдүүлдэг эрчим хүчний том компани юм. “Газпром” дэлхийн байгалийн хийн нөөцийн 18%, орос улсын байгалийн хийн нөөцийн 70%-ийг эзэмшдэг, дэлхийн байгалийн хий олборлолтын 15%, оросын байгалийн хий олборлолтын 78% оногддог. Ойрх болон Алс дорнодын 30 гаруй оронд хий нийлүүлдэг, шатсан байгалийн хий үйлдвэрлэгч, экспортлогч оросын цорын ганц компани бөгөөд дэлхийн шатсан байгалийн хий үйлдвэрлэлийн 5%-ийг хангадаг байна.⁷

Айлчлалын үеэр хятадын шууд хөрөнгө оруулалтыг дэмжсэн хэд хэдэн гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурав. Оросын Зүүн Сибирийг хөгжүүлэх, нүүрс олборлох төслийг хэрэгжүүлэх хэлэлцээрт Оросын “En+Group”, Хятадын “Shenhua Group” корпораци гарын үсэг зурав. Хятадын Хөгжлийн банкнаас хамтарсан төслийг санхүүжүүлэхэд ойролцоогоор 2 тэрбум ам.доллар гаргах болсон байна. Эдгээр хэлэлцээрийн дагуу нүүрс хайх, олборлох, боловсруулахад хамтран ажиллаад зогсохгүй, түүний дагалдах дэд бүтцийг хөгжүүлэх, тухайлбал, төмөр зам, авто зам барих, нефть олборлох, боловсруулах, төслийн эрчим хүчний хангамжинд зориулан цахилгаан станц барьж байгуулах ажлууд орж байгаа нь Оросын Алс Дорнодын бүс нутгийн хөгжилд түлхэц үзүүлнэ гэж оросын тал үзэж байна. Үүний зэрэгцээ Алс Дорнодын боомтын хүчин чадлыг нэмэгдүүлж, Хятад болон

Азийн бусад орны нүүрс хэрэглэгчдэд нүүрс худалдах, нийлүүлэх ажлыг боловсронгуй болгохоор тохиролцсон байна. Хятад улс дэлхийн нүүрсний хэрэглээний 50 гаруй хувийг эзэлдэг бөгөөд томоохон нүүрс импортлогч орон юм. Хятад улсад том хэмжээний цахилгаан станц баригдаж байгаатай холбоотой нүүрсний эрэлт байнга өсөн нэмэгдэж байгаа бөгөөд хятадын эрчим хүчний 70 гаруй хувь оногдож байна. Хятадад нүүрс нийлүүлэгч гол орнууд бол Австрали, Индонез юм. Оросын нүүрс олборлогч “En+Group” нь 2008 оноос нүүрс олборлож байгаа бөгөөд 4 тэрбум гаруй тонн нүүрсний нөөц бүхий орд газрыг эзэмшдэг, Зүүн Сибирь болон Казакстан дахь орд газруудаасаа жилд 50 гаруй сая тонн нүүрс олборлодог, 2012 оноос эхлэн Хятад болон Азийн бусад орон руу нүүрс нийлүүлж байгаа компани юм.⁸

ОХУ-ын Эрчим хүчний яам болон Хятадын эрчим хүчний хороо нефть, байгалийн хийн үйлдвэрлэлд хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурав. Айлчлалын үеэр нефть хайх, олборлох, түүхий нефть худалдах салбарын хүрээнд Тяньжиний нефть боловсруулах үйлдвэрийг барьж, ашиглалтанд оруулах хамтын ажиллагааны хэлэлцээрт гарын үсэг зурсан байна. Уг төслийг хэрэгжүүлэхийн тулд Оросын “Роснефть” компани 49%, Хятадын нефтийн корпораци 51%-ийн эзэмшилтэйгээр Орос-Хятадын хамтарсан нефть-химийн компанийг байгуулаад байна. Энэ хамтарсан үйлдвэрийг 2015 он гэхэд барьж дуусахаар төлөвлөж байгаа бөгөөд тус үйлдвэр нь жилд 13 сая тонн нефть боловсруулж түүнээс 9 сая тонн нь оросын түүхий нефть эзлэх юм.

“Роснефть” болон «Синопек» корпорацийн хооронд бүх талын хамтын ажиллагааны тухай протоколд гарын үсэг зурсан байна. Уг протоколын дагуу хоёр тал Сахалин-3 төслийн ажлыг боловсронгуй болгох талаар тохиролцов.

Оросын “Русал” компани, Хятадын хөнгөн цагааны “Chalco” корпорацийн хооронд хөнгөн цагааны хүдэр боловсруулалт, хөнгөн цагаан үйлдвэрлэлийн шинэ технологийн салбар дахь эрдэм шинжилгээ, судалгааны төслийн хамтын ажиллагааны харилцан ойлголцох санамж бичигт гарын үсэг зурсан байна.⁹ “Русал” компанид дэлхийн хөнгөн цагаан үйлдвэрлэлийн 10% оногддог, 19 оронд салбартай, жилд 4,7 сая тонн хөнгөн цагаан үйлдвэрлэх хүчин чадалтай том компани юм. Европ, Хойд Америк, Зүүн өмнөд Азийн орнуудын зах зээлд бүтээгдэхүүнээ борлуулдаг бөгөөд Хятад улс руу 100 мянга гаруй тонн хөнгөн цагаан нийлүүлдэг байна. 2012 оны 4 дүгээр сард “Русал” компани нь хятадын машин

үйлдвэрлэлийн NORINCO корпораци хамтран Хятадад North United Aluminium хэмээх хамтарсан үйлдвэр байгуулах ажлыг эхлээд байгаа бөгөөд Хятадын зах зээлд хөнгөн цагаан, хайлш бусад өнгөт металл нийлүүлэлтийн ажлыг гүйцэтгэх юм. “Русал” компани нь тус хамтарсан үйлдвэрээр дамжуулан хятадын зах зээл дэх хөнгөн цагааны борлуулалтыг жилд 200-300 мянган тонноор нэмэгдүүлэх боломжтой гэж найдаж байгаа юм.

Орос, Хятад хоёр орны цэрэг техникийн салбарын уламжлалт хамтын ажиллагаа нь стратегийн хамтын ажиллагааны түвшний нэг чухал хэлбэр юм. Айлчлалын үеэр БНХАУ-ын дарга Си Зиньпин Оросын Батлан хамгаалах яам ба Холбооны зэвсэгт хүчний байлдааны төвтэй танилцан, ОХУ БНХАУ-д “Лада” ангиллын дизелийн хөдөлгүүртэй 4 шумбагч онгоц барих, 24 ширхэг Су-35 байлдааны онгоц нийлүүлэх гэрээнд гарын үсэг зурсан байна.

Хоёр тал хоёр орны соёл, хүмүүнлэгийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар хэд хэдэн баримт бичигт гарын үсэг зурав. БНХАУ-ын дарга Си Зиньпиний санаачлагаар 2014-2015 оныг ОХУ болон БНХАУ-ын хооронд залуучуудын солилцооны жил болгохоор тохиролцсон байна. Энэ үеэр “Хил, хязгааргүй дэлхий” олон улсын аялал жуулчлалын нэгдэл ба Гуандун мужийн аялал жуулчлалын газрын хооронд арилжааны бус түншлэлийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээр, Санкт-Петербургийн эдийн засгийн их сургууль, Хятадын аялал, жуулчлалын хүрээлэн, Хэйлунзянийн их сургуулийн хооронд аялал жуулчлал, дээд боловсрол, эрдэм шинжилгээний салбар дахь хамтын ажиллагааны тухай хэлэлцээр, Орос-Хятадын клуб ба Хятадын Хайнань мужийн аялал, жуулчлал хөгжүүлэх хорооны хооронд стратегийн хамтын ажиллагааны хэлэлцээрт тус тус гарын үсэг зурав. Өмнөх жилүүдэд зохиогдсон соёл, урлаг болон боловсролын томоохон арга хэмжээнүүд нь хүмүүнлэгийн салбарын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхэд нөлөөлсөн гэж талууд үзэж байна. Тухайлбал, хятад, орос хэлний жилүүд болж өнгөрсний зэрэгцээ, 2012-2013 оны “Хятад дахь оросын аялал жуулчлалын жил”-ийн хүрээнд “Бээжин-Москва авто аялал”, “Сайн байна уу, Орос орон”, “1000 хятадын жуулчид Орост аялж байна” зэрэг 200 гаруй арга хэмжээ зохиогдоод байна. 2015 гэхэд хоёр тал, хоёр орны жуулчдын тоог 5 саяд хүргэхээр төлөвлөж байна.¹⁰

Түүнчлэн “Оросын дуу хоолой” радиостанц, хятадын “Жэнминьван” интернет-портал болон “Хятадын олон улсын радио”-гийн хооронд мэдээллийн хамтын ажиллагааны тухай хоёр

хэлэлцээрт гарын үсэг зурав. “Оросын дуу хоолой” радиостанц нь 1929 оноос үйл ажиллагаагаа явуулж байгаа, дэлхийн 31 хэл дээр нэвтрүүлэг бэлтгэн явуулдаг хэвлэл мэдээллийн том компани юм. Энэхүү хамтын ажиллагаа нь хоёр орны найрамдал, нөхөрлөл, түүх, хэл, соёлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчилахад чухал үүрэгтэй гэж талууд үзэж байна.¹¹

Хоёр тал НҮБ, “Их-20”, БРИКС, Шанхайн хамтын ажиллагааны байгууллагуудын хүрээнд нягт уялдаатай ажилладаг бөгөөд хоёр орны хамтын ажиллагаа нь Ази-Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чухал үүрэгтэй. НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн байнгын гишүүн орон, дэлхийн хоёр том эдийн засагтай орнуудын хувьд стратегийн түншийн харилцаа нь зөвхөн хоёр талд бус, олон улсын хэмжээнд чухал ач холбогдолтой талаар хоёр орны удирдагчид уулзалтын үеэр онцлон тэмдэглэсэн байна.

Монгол улс нь тус хоёр хүчирхэг гүрний дунд оршдог, эдийн засгийн хувьд хоёр хөршөөсөө хамааралтай байдгийн хувьд уул уурхай, дэд бүтэц, эрчим хүч, газрын тос, хөдөө аж ахуй зэрэг эдийн засгийн гол салбарууд дахь хамтын ажиллагааг хоёр хөрштэйгөө өргөжүүлэн хөгжүүлэх, Монгол, Хятад, Орос гурван улсыг холбосон төслүүдийг хэрэгжүүлэх, хөрш хоёр орон ОХУ, БНХАУ-ын хооронд байгуулах газрын тос, байгалийн хий, цахилгаан дамжуулах шугамын төслүүд зэрэг хэрэгжүүлэхээр тохиролцсон дээрх төслүүдэд Монгол Улс оролцох сонирхолтой байгаа бөгөөд энэ тухайгаа ч монголын тал энэ оны 4-р сард БНХАУ-ын Хайнань мужийн Боао хотод болсон “Азийн төлөөх Боаогийн чуулга уулзалт”-ын үеэр БНХАУ-ын дарга Си Зиньпинтэй уулзахдаа илэрхийлсэн.

Нефтийн нийлүүлэлтээ нэмэгдүүлэх хүрээнд ОХУ-аас БНХАУ-ын баруун хэсэг рүү төмөр зам тавихдаа үр ашигтай замаар тээвэрлэх асуудал тавигдаж байна. Анхаарал татсан нэг асуудал бол Сквородино-Мохэ, Дорнод-Сибирь-Номхон далайн чиглэлийн дамжуулах хоолойн хүчин чадлыг нэмэгдүүлэх, Казахстангаар дамжих шинэ чиглэл бий болгох зэрэг нефть тээвэрлэх гурван хувилбар яригдаж байгаагийн нэг нь Монгол улсын нутгаар дамжуулж болох тухай Транснефтийн төлөөлөгчийн мэдэгдэл юм. 7 сая тонн нефть Казахстаны Атасу-Алашанькоу нефтийн хоолойгоор дамжуулан тээвэрлэхэд экспортын татварт Казахстанд 80 тэрбум руб. төлөх юм. Энэ нь 1 тонн нефть 420,6\$ болж байна. Транснефтийн байр суурийг аваад үзэхэд Хятадын баруун хэсэг руу төмөр замаар Монгол улсын нутгаар транзитаар тээвэрлэж болох бөгөөд өмнө нь нийт 7 сая тонн нефтийн 2 сая тонныг Забайкальск-Манжуурын

хилээр Хятадын Дачинд, 5 сая тонн нефтийг Наушкийн хилийн боомтоор Монгол улсын нутгаар транзитаар тээвэрлэж байсан туршлага байгаа ба монголын тал тээвэрлэлтийн хөнгөлөлт үзүүлж байсан учир боломжтой гэж үзэж байна. Монголын чиглэл ачаалал багатай нийт хүчин чадлынхаа 20%-ийг ашигладаг. Хэрэв Монголын нутгаар дамжуулахаар болбол хоолойны уртыг 1000 орчим километрээр багасгаж, нэлээд зардал хэмнэх боломжтой юм. Энэхүү чиглэл нь нөгөө талаасаа Сибирь, Алс Дорнодыг хөгжүүлэх ОХУ-ын нийгэм-эдийн засгийн бодлоготой нийцэж байгаа бөгөөд Эрхүү мужийг хөгжүүлэх боломж бүрдэнэ гэж үзэж байна. Харин “Роснефть” энэ хувилбарын хувьд ашиггүй гэсэн байр суурьтай байгаа юм. Учир нь Эрхүү мужийн Меget станц нь Казахстанас байршлын хувьд хол гэж үзэж байна.

Монгол улсын хувьд энэхүү транзит тээврээс их хэмжээний ашиг олох, эрчим хүчний эх үүсвэртэй болж, нүүрсний хэрэглээгээ эрс багасгах, цахилгааны нөөцтэй болохын зэрэгцээ Оюутолгой, Тавантолгой зэрэг томоохон төслүүдийн зардлыг хэмнэх зэрэг олон зэрэг үр дагавартай юм.

ДУГНЭЛТ

БНХАУ-ын дарга Си Зиньпиний ОХУ-д хийсэн айлчлал нь Орос, Хятадын худалдаа, эдийн засгийн харилцааны хөгжил дээд түвшинд хүрч, стратегийн түншлэлийн хэлбэр нь хоёр талын болон бүс нутгийн хамтын ажиллагаанд хэвээр хадгалагдан шинэ агуулгаар баяжиж, улам өргөжиж байгааг харууллаа. Хоёр орны эрчим хүчний салбарын хамтын ажиллагаа өргөжин, ОХУ-аас БНХАУ руу нийлүүлэх нефть, байгалийн хийн хэмжээг нэмэгдүүлэхээр тохиролцон урт хугацааны хамтын ажиллагааны баримт бичгүүдэд гарын үсэг зурлаа. ОХУ, БНХАУ-ын хооронд байгуулах газрын тос, байгалийн хий, цахилгаан дамжуулах шугамын төслүүд зэрэг хэрэгжүүлэхээр тохиролцсон дээрх төслүүдэд Монгол Улс оролцох боломж гарч ирэх магадлал байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

1. Совместное заявление Российской Федерации и Китайской Народной Республики о взаимовыгодном сотрудничестве и углублении отношений всеобъемлющего партнёрства и стратегического взаимодействия. 22 марта 2013 г. Москва.

2. Обзор российско-китайской торговли в 2012 г.

http://www.russchinatrade.ru/assets/files/ru-ru-cn-coop/ru_

ch_trade_2012.pdf

3. Соглашение об основных условиях поставок сырой нефти на условиях предоплаты между Открытым акционерным обществом «Нефтяная компания «Роснефть»» и Китайской национальной нефтегазовой корпорацией; 22 марта 2013 г. Москва.

4. Российско-китайская нефть. Эксперт. 20 июня 2013.

<http://expert.ru/2013/06/20/rossijsko-kitajskaya-neft/>

5. Роснефть сегодня. <http://www.rosneft.ru/about/>

6. Газпром и Роснефть подписали соглашения с китайской CNPC. // Вгляд. Деловая газета. 22 марта 2013.

<http://www.vz.ru/news/2013/3/22/625615.html>

7. О газпроме. <http://www.gazprom.ru/about/>

8. Банк развития Китая будет финансировать проекты добычи угля в России.

<http://polcoaldex.pl/ru/wegiel/913-chi%C5%84ski-bank-rozwoju-sfinansuje-projekty-wydobycia-w%C4%99gla-w-rosji.html>

9. РУСАЛ и Chalco усилят сотрудничество в алюминиевой отрасли.

[http://www.rusal.ru/press-center/press-releases.aspx?](http://www.rusal.ru/press-center/press-releases.aspx?dyncont=8475)

[dyncont=8475](http://www.rusal.ru/press-center/press-releases.aspx?dyncont=8475)

10. О гуманитарных обменах Китая и России. Китайский информационный центр.

<http://russian.cri.cn/1143/2013/03/19/1s461455.htm>

11. Сайт «Жэньминьван» и радиостанция «Голос России» подписали соглашение о сотрудничестве.

<http://russian.people.com.cn/31519/8179820.html>

Abstract:

Chinese President Xi Jinping visited Russia on a working visit. The talks which attracted worldwide attraction were held in Moscow from 22 to 24 March 2013. During the talks, Russia and China signed 35 agreements on cooperation. The two leaders discussed trade and economic cooperation in the fields of the high-tech, environmental protection, culture and tourism. During the visit, the two leaders signed a joint statement between China and Russia on mutual cooperation and deepening the relations of a comprehensive strategic partnership of cooperation.